



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 03 өдөр

Дугаар 1/506

Чингис хот

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.1.13, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.3-д заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшиг осолтой тэмцэх, хохирлыг богино хугацаанд арилгах зорилгоор тус аймагт Бүгд Найрамдах Солонгос улсын Сөүл хотын Гал, гамшгийн удирдах газраас тусламжаар олгох гал унтраах үндсэн албаны автомашин 2020 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр Солонгос улсын Инчеон боомтоос ачигдаж ирэх тул олон улсын тээврийн зардал, гаалийн татвар, түлшний зардлыг тооцож олгосугай.

2. Зардлын төрөл, мөнгөн дүнг хавсралтаар баталсугай.

3. Шаардагдах 20256400 /хорин сая хсёр зуун тавин зургаан мянга дөрвөн зуу/ төгрөгийг Засаг даргын нөөц сан, гамшгийн эрсдэлээс хамгаалах сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т зөвшөөрсүгэй.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч /Ц.Чогсомжав/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010868

110... Аймгийн Засаг даргын 2020 оны
дугаар сарын 03 өдрийн А/506
дугаар захирамжийн хавсралт

УЛС ХООРОНДЫН ТЭЭВРИЙН ЗАРДАЛ

№	Зардлын төрөл	Нэгж үнэ	Нийт үнэ	Тайлбар
1	Олон улсын тээврийн зардал	18,218,200 төгрөг	18,218,200 төгрөг	Тээврийн даатгалын үнэ багтсан болно.
2	Гаалийн татвар	1,300,000 төгрөг /орчим/	1,300,000 төгрөг /орчим/	Гаалийн татварыг гаалийн бүрдүүлэлт хийх үед тооцоолно.
3	Дизель түлш	50,000 төгрөг	50,000 төгрөг	Автомашинуудын түлшний банкыг хоосолж ачдаг тул банкандаа түлшгүй ирдэг.
Зардлын дүн			19,568,200 төгрөг	

ШАТАХ ТОСЛОХ МАТЕРИАЛЫН ТООЦОО

№	Явах машин	Явах маршрут	явах зай /км/	Норм шатахуун		Зарцуулах шатахуун	Нэг бүрийн үнэ	нийт үнэ
				нэр төрөл	литр			
1	Хюндай маркын гал унтраах автомашин	Замын-Үүд-Налайх	625	ДТ	40	250	1850	462500
		Налайх-Чингис хот	305		40	122	1850	225700
Шатахууны дүн			930			372		688200
Нийт								20,256,400